



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын их сургуулийн

Олон улсын харилцаа нийтийн удирдлагын сургууль

Хөтөлбөрийн нэр: Олон улсын харилцаа

Индекс: D031202

Шинжээчийн баг:

Ахлагч: С.Эрдэнэтуул

Гишүүд: И.Энхболд

Н.Хосбаяр

Он сар өдөр: 2021.11.15

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа	10
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	12
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	14
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	17
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа	20
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт	22
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	
I. Багш нарын нэрс	28
II. Оюутнуудын нэрс	28
III. Ажил олгогчдын нэрс	29
IV. Төгсөгчдийн нэрс	30
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	31
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Монгол хэлээр

АХБ	Азийн хөгжлийн банк
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх ухаан Спортын Яам
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам
БШУЯ	Боловсрол, Шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДБ	Дэлхийн банк
МУИС-	Монгол Улсын Их Сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОУХ	Олон улсын харилцаа
ОУХДС	Олон улсын харилцааны дээд сургууль
ОУХНУС	Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль
ОУХС	Олон улсын харилцааны сургууль
ОУСХ	Олон улс судлалын хүрээлэн
ССХ	Стратегийн судалгааны хүрээлэн
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ХДХ	Хөтөлбөрийн дэд хороо
ХЕХ	Хөтөлбөрийн ерөнхий хороо
ХЧБХ	Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс
ШУА	Шинжлэх ухааны академи
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
Англи хэлээр	
LO	Learning outcomes-суралцахуйн үр дүнгүүд
PEO	Program Educational Objectives- хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд
PLO	Program Learning Outcomes- хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд
CLO	Course Learning Outcomes-хичээлийн суралцахуйн үр дүнгүүд

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын их сургуулийн Олон улсын харилцаа нийтийн удирдлагын сургууль School of international relations and public administration, National university of Mongolia	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Олон улсын харилцаа International relations	
Индекс	D031202	
Шинжээчид	<p>Шинжээчийн багийн ахлагч: С.Эрдэнэтуул - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Академик чиглэл хариуцсан дэд захирал, доктор</p> <p>Шинжээчийн багийн гишүүд: И.Энхболд – Шинжлэх ухааны академийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Н.Хосбаяр- Отгонтэнгэр их сургуулийн Гадаад харилцааны албаны дарга, доктор</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Б.Мядагмаа – Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2021.10.27	/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/ Урьдчилсан үнэлгээний тайланг сургуульд хүргүүлсэн.
	2021.11.02 – 11.03	Сургууль дээр ажиллаж, оролцогч талуудтай уулзаж, нотлох баримтуудтай танилцсан.
	2021.11. 12	Шинжээчийн багийн тайланг БМИҮЗ-д хүргүүлсэн.
	2021.11.12	Шинжээчийн тайланг БМИҮЗ-ийн мэргэжилтэн сургуульд хүргүүлж сургуулийн саналыг авсан.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1991 онд ОУХС байгуулагдаж, гадаад албаны ажилтан бэлтгэж эхэлсэн. 2002 оноос олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцаа гэсэн мэргэжлээр 128 багц цагийн сургалтын хөтөлбөрийн дагуу мэргэжилтэн бэлтгэж байсан бол, 2011 онд сургалтын төлөвлөгөөг шинэчлэн 120 багц цагийн агуулгатай болгосон байна. Улмаар 2014 оноос одоогийн олон улсын харилцааны мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2018 онд зарим агуулгын шинэчлэлийг хийн, 121 багц цагийн сургалтын төлөвлөгөөг баталж, сургалтад мөрдөж байна. Энэхүү хөтөлбөрийг анх 2013 онд БМИҮЗ-ээр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлүүлсэн.

2021-2022 оны хичээлийн жилд Олон улсын харилцаа хөтөлбөрийг хэрэгжүүлэгч МУИС-ийн Олон улсын харилцааны тэнхим нь 14 үндсэн багш 1 зөвлөх багш, 1 туслах ажилтны бүрэлдэхүүнтэй бүрэлдхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс, профессор 1, дэд профессор 6, ахлах багш 4, багш 3, зөвлөх дэд профессор 1 байна.

Жилд ойролцоогоор 140 орчим суралцагчийг элсүүлж, тэдний 70-80 хувь нь хугацаандаа төгсдөг байна. Тус хөтөлбөрөөр суралцагчдын 67% нь ямар нэгэн олон улсын болон үндэсний тэтгэлэгт хөтөлбөрт хамрагддаг, элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо 700-аас дээш байна. Гадаад оюутны тоогоороо МУИС-даа тэргүүлдэг хөтөлбөр бөгөөд одоогийн байдлаар 29 оюутан суралцаж байна. Суралцагчдын бүтээлч үйл ажиллагаа, хөгжлийг дэмжих “Дипломат”, “SRT Mongolia”, “Mongolia Model UN”, “Intro” клубууд зөвхөн сургууль, МУИС-ийн хэмжээнд бус үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулдаг.

Албан бус судалгаагаар нийт оюутнуудын 25 хувь нь ямар нэгэн олон улсын болон үндэсний тэтгэлэгт хөтөлбөрт сурлага, амжилтаараа шалгардаг. Дипломат албанд төдийгүй аюулгүй байдал, олон улсын харилцааны чиглэлээр судалгаа явуулдаг үндэсний тэргүүлэх хүрээлэнгүүдэд тус сургуулийн төгсөгчид ажиллаж байна. Монгол улсын ҮАБЗ-ийн дэргэдэх ССХ-ийн судлаачдын 10 хувь, ШУА-ийн ОУСХ-ийн 26 хувь, ГХЯ-ны боловсон хүчний 43 хувийг энэ хөтөлбөрийн төгсөгчид эзлэж байна. Мөн Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ийн тамгын газар зэрэг байгууллагад төгсөгчид ажилладаг төдийгүй Оюутолгой, Тавантолгой компанид төгсөх ангийн оюутнууд голчлон дадлага хийж, үндсэн ажилтан болох уламжлал тогтжээ. Үүнээс Оюутолгойд ажиллаж буй төгсөгчдийн тоо жил тутам өсч байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Олон улсын харилцааны хөтөлбөрийг UNESCO-ийн мэргэжлийн ангилалд нийцүүлэн боловсруулж, PDCA циклийн дагуу байнгын сайжруулалт хийж байна.
- Тус хөтөлбөр нь олон салбарын уулзвар дээр мэргэжилтэн бэлтгэх шинжийг агуулсан. Улс төр, эрх зүй, гадаад хэл, дипломат ёс, ёслол, олон улсын харилцааны чадамж олгох хийчээлийг агуулсанаас гадна чөлөөт сонголтоор бусад салбарын хичээлүүдийг сонгон судлах боломжийг олгосон.
- Хөтөлбөрийн STEEP шинжилгээг хийж, ажил олгогчдын судалгааны үр дүнд тулгуурлан, төгсөгчийн загвараа тодорхойлсон.
- Олон улсын түвшинд Харвард, Стэнфорд, Эллиотын их сургуулийн ижил төстэй хөтөлбөртэй харьцуулалт хийснээс гадна үндэсний хэмжээнд Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн хөтөлбөртэй харьцуулалт хийж, давуу, сул талаа тодорхойлжээ.
- Дээрх шинжилгээнүүдийг хийсний үндсэн дээр Бүс нутаг судлал хичээлийг гүнзгийрүүлэн судлахаар сургалтын хөтөлбөрт тусгаснаас гадна хичээлийн агуулгад дипломат ажиллагаа, яриа хэлэлцээ явуулах урлаг, олон улсын эдийн засгийн харилцааны чадамжийг олгохоор өөрчлөлтүүдийг оруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн STEEP, SWOT шинжилгээг хийж, хөтөлбөрт байнгын сайжруулалт хийж байна.
- Гадаадын сургуулиудын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулалт хийж, давуу, сул талаа дүгнэснээс гадна тэднээс бенчмаркинг хийх чиглэлээ тогтож, хөтөлбөртөө шингээсэн.
- Үндсэн мэргэжлээс гадна тухайн суралцагчийн төгсөөд ажиллах салбартай уялдаатайгаар бусад хөтөлбөрийн хичээлүүдээс сонгох боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын судалгааг хийж, үр дүнг төгсөгчийн загварын сайжруулалтад ашиглаж байгаа боловч, төлөөлөх чадварыг цаашид анхаарах.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- “Монгол улсын гадаад бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, олон улсын харилцааны нөхцөл байдалд дүн шинжилгээ, үнэлэлт дүгнэлт өгч чадахуйц мэдлэг, чадвартай олон улсын улс төр, эдийн засаг, эрх зүйн харилцааны чиглэлээр мэргэшсэн гадаад хэлний өндөр мэдлэгтэй, гадаад харилцааны салбарт ажиллах чадвар, дадал эзэмшсэн олон улсын харилцааны мэргэжилтэн бэлтгэх” хэмээн хөтөлбөрийн зорилгоо тодорхойлсон нь МУИС, ОУХНУС-ийн эрхэм зорилго, алсын хараатай нийцэж байна.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг тодорхойлж, суралцахуйн зорилтот үр дүнгүүдийг мэдлэг, мэргэжлийн чадвар, хөрвөх чадвар, хандлага гэсэн 4 бүлэгтэйгээр тодорхойлсон.
- 2016 онд 23, 2018 онд 14 ажил олгогчийг түүвэр байдлаар сонгон, хөтөлбөрийг үнэлүүлсэн бөгөөд үнэлгээний дундаж үзүүлэлт сайн гарсан.
- Тус хугацаанд төгсөгчийн төлөөллөөс сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны үр дүнд албан баримт бичиг боловсруулах чадвар олгох хичээлийг сонгонд тусгаж өгсөн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн стратеги, бүрэлдэхүүн сургуулийн стратеги уялдаа холбоотой тодорхойлогдсон.
- Оролцогч талуудын хамтарсан уулзалтыг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлсэн.
- Хөтөлбөрийн хороонд ажил олгогч, төгсөгчдийн төлөөллийг оруулснаар тэдний саналыг тусгах боломж бүрдсэн.
- Ажил олгогчдын судалгаа, ярилцлагаас харахад, мэргэжлийн хувьд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Олон улсын харилцаа хөтөлбөр нь “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу 121 багц цагийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх бүлгүүдийн хичээлүүдийг тусгаснаас гадна энэхүү бүлгүүдийн харьцаа шаардлагад заасны дагуу тодорхойлогдсон байна.

- 2014 онд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, хэрэглээнд оруулсан бөгөөд 2018 онд агуулгын зарим шинэчлэлүүдийг хийн, сургалтын төлөвлөгөөгөө шинэчилжээ.
- Сургалтын төлөвлөгөөнд туссан хичээлүүдийн хөтөлбөрийг боловсруулах сайжруулсан загварыг хэрэглээнд оруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2014 онд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж, хэрэглээнд оруулсан бөгөөд 2018 онд агуулгын шинэчлэл хийсэн байна.
- Ажил олгогч, төгсөгчдөөс авсан судалгааны үр дүнд тулгуурлан сургалтын төлөвлөгөөнд 2 удаагийн өөрчлөлтийг оруулсан байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн хөтөлбөрүүдийг тухайн хичээлээр олгох үр дүнтэй хэрхэн уялдаж байгааг харж болохуйц байдлаар боловсруулж, он сар, гарын үсгээр баталгаажсан байхад анхаарах.
- Шинээр хэрэглээнд орсон хичээлийн хөтөлбөрийн загварын дагуу бүх хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, баталгаажуулах.

Шаардлага:

- Хөтөлбөрийн боловсруулалт, баримт бичгийн бүрдэлд сайжруулалт хийх.
- Хөтөлбөрийн маппинг – ийг илүү ур чадварыг нарийвчлан тодорхойлсон чиглэлээр боловсруулахаас гадна олгож буй ур чадварыг түвшинчлэх.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- 2000 онд Сургалтын агуулга шинэчлэгдэн гадаад хэл суурьтай бус олон улсын харилцаа суурьтай болсон.
- 2014 онд Сургалтын агуулга дахин шинэчлэгдэж оюутны сонголтод тохирсон хичээлийг зааж эхэлсэн.

Мэргэжлийн хичээлийн агуулга

- Дипломатын шинжлэх ухаантай холбоотой хичээлүүд орж байгаа нь сургуулийн давуу тал болжээ. Энэ нь төгсөгч нарын бусадтай харилцах чадвар, манлайлах, илтгэх, ярих чадвар эзэмшсэн байгаа нь харагдлаа.
- Монгол Улсын гадаад харилцаа хичээлийг үндэсний үзэл, гадаад бодлоготой холбогдуулан оюутнуудад зааж байгаа нь аль улстай хэрхэн харьцах тал дээр чиглүүлж өгсөн байна. Орос, Украин зэрэг улс орнуудын байгууллагуудтай харьцан ажиллаж байна.
- Дипломат орчуулга 1, 2, 3 хичээлийн үр дүн сайтай байгаа нь оюутан, ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн уулзалтаар батлагдав.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийн онцлог нь олон улсын харилцаа, дипломат харилцаа аль алиныг нь хослуулсан гадаад хэлний өндөр чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд оршиж байна.
- Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу харьцаанууд тодорхойлогдсон.
- Чөлөөт сонголтоор бусад салбарын мэдлэг, мэдээлэл олж авах боломжтой.

Анхаарах асуудал:

- Гадаадын олон улсын харилцааны сургуулиуд 3-4-н хэлийг зэрэг эзэмшүүлэхэд анхаарч байгааг цаашдын төлөвлөлтөд харгалзан үзэх.
- 2 дахь гадаад хэлийг 3 улирал үзэж байгаа нь гадаад хэлний чадварыг өндөр түвшинд эзэмшүүлэхэд хангалтгүй байгааг оролцогч талууд илэрхийлж байсныг анхаарах.

Шаардлага:

- Гадаад хэлний өндөр ур чадварыг олгохын тулд хөтөлбөр дэхь гадаад хэлний багц цагийг нэмэгдүүлэх боломжийг судлах.
- Дижитал шилжилт, аж үйлдвэрийн хувьсгалтай уялдаатайгаар “технологи ба олон улсын харилцаа” чиглэлийн хичээлийг хөтөлбөрт нэмэлтээр тусгах.
- Агуулгын шинэчлэлийг харьцуулж харах боломжийг бүрдүүлж, агуулга шинэчлэгдсэнээс хойш гарсан үр дүнд шинжилгээ хийж хэвших.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах нэгдсэн заавартай.
- Сургалтын арга зүйн удирдамжтай.
- Заах арга зүйтэй холбоотой хичээл үзсэн оюутнуудаас авсан санал асуулгын судалгаа хийгдсэн.
- Мини НҮБ арга зүйн гарын авлагыг хэвлүүлэн, хэрэглээнд оруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мини НҮБ сургалтын арга зүй үндэсний түвшинд өргөжиж байгаа нь шинэ санаачилга болжээ.
- Оюутны клубүүдийг олноор нээж, төсвөөр хангаж өгснөөр харилцааны соёлд суралцах, багаар ажиллах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг бусад чадварыг суулгаж өгсөн давуу тал ажиглагдлаа.
- Тоглох, бүтээл хийх, видео контент бүтээх зэрэг стимуляцийн бусад аргыг өргөнөөр ашиглах болсон байна.
- Багш нар цахим хичээлийн өгөгдлийн сантай, арга зүйтэй болсон байна.
- Сургалтын арга зүйн шинэчлэлийг тогтмол хангах багшийн хөгжлийн төвтэй болсон байна.
- Оюутнууд багшийг, хичээлийг сонгох боломж бүрэн шийдэгдсэн.

Анхаарах асуудал:

- Заах арга зүйтэй холбоотой хичээл үзсэн оюутнуудаас авсан санал асуулга дээр дүгнэлт алга байна. Судалгааны үр дүнд дүгнэлт хийн, цаашдын төлөвлөгөөнд тусгаж байх.
- Судалгаа, шинжилгээний арга зүйг доод түвшингүүдэд олгох тал дээр анхаарах.

Зөвлөмж:

- Судалгаа шинжилгээний арга зүйг эзэмшүүлэх хичээлийг санал болгож буй улирлыг өөрчлөх боломжийг судалж, сургалтын төлөвлөгөөнд тусгах.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын журмыг баталж, журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулдаг. Оюутныг үнэлэх, дүгнэх журам хэрэглээнд орсон.
- Төгсөгчийг загварыг суралцагчид олгох мэдлэг, чадвар, хандлага гэсэн цогц чадамж байдлаар тодорхойлон гаргасан.
- Багш бүр үнэлгээний тогтсон арга зүйтэй, түүнийгээ хичээлийн хөтөлбөрт тусгасан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үнэлгээтэй холбоотой гомдол маргааныг богино хугацаанд шийдвэрлэдэг болсон.
- Багшийн кейсийн болон тестийн сан бүрдсэн. Хичээлийн хэрэглэгдэхүүнүүд болон үнэлгээний даалгаврууд цахим хэлбэрт шилжсэн.

Анхаарах асуудал:

- Хичээлийн суралцахуйн зорилтот үр дүнтэй уялдсан үнэлгээний арга зүйг тодорхой болгож, үнэлгээний рубрикүүдийг хэрэглээнд оруулах.

- Оюуны өмч, зохиогчийн эрх ашигласан байдлыг хянадаг системтэй болох.
- Багшийн ачааллыг тэнцвэржүүлэх тал дээр анхаарч, багшийн 1 оюутны үнэлгээг хийхэд зарцуулах бодит хугацааг бодолцох.

Зөвлөмж:

- Гадаад хэлний чадварын хувьд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээг нэвтрүүлэх боломжийг хайх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт явуулах анги, танхимууд проектороор бүрэн тоноглогдсон.
- Сургуулийн аль ч хэсэгт интернетэд орох боломжтой, утасгүй сүлжээний технологийг бүрэн нэвтрүүлсэн.
- Номын сангийн хүртээмжийг сайжруулж, МУИС-ийн шинэ төв номын санг ашиглалтад оруулснаас гадна ОУХНУС – ийн номын сан ажилладаг.
- Суралцагчид нээлттэй эх үүсвэрүүдээс судалгааны ажил авч ашиглах боломжийг бүрэн олгосон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС – ийн номын сангийн хүртээмж, орчин нөхцөл сайн.
- Бүх түвшний суралцагчид нээлттэй судалгааны сангуудаас материалуудаа авч ашиглах боломж бүрдсэн.
- Суралцагчдаас нэн шаардлагатай байгаа ном, сурах бичгийн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэдэг соёл тогтсон.

Анхаарах асуудал:

- Танхимаар хичээллэж буй нөхцөлд, суралцагчийн дээд хязгаарыг барих тал дээр анхаарах.
- Сургууль цайны газаргүй байгаа нь суралцагчид болон багш нарын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.
- Ариун цэврийн өрөөний агааржуулалтыг сайжруулах.

Зөвлөмж:

- Багш, суралцагчдад зориулсан цайны газар, кофе шопыг бий болгох.

- Хичээлийн бус цагаар оюутнууд багаар ажиллах боломжит танхимуудыг тохижуулах, хэрэглээнд оруулах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалт, судалгааны програм хангамж, хичээлийн хэрэгслийг тэнхим сургуулийн төлөвлөгөөнд тусгуулан, тухай бүр шийдүүлж байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүн болох, ном, сурах бичгийн бүрдүүлэлт, баяжуулалтыг жил бүр хийж байна.
- Цахим сургалтын Microsoft Teams програмыг ашиглан багш нар өөрийн хичээлийн видео контентыг хийн байршуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ном сурах бичиг оюутнуудад хангалттай төдийгүй цахимаар үзэх боломжтой тул, хэрэгтэй материалаар сайн хангаж байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүн болох, ном, сурах бичгийн бүрдүүлэлт, баяжуулалтыг жил бүр хийж байна. Суралцагчид чиглэсэн үйлчилгээнд зарцуулах зардал сүүлийн жилүүдэд өссөн дүнтэй байна.

Анхаарах асуудал:

- Цахим сургалтын платформд багшийн оруулсан хичээлүүд харилцан адилгүй байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Гадаад, дотоодын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн байнгын захиалгыг нэмэгдүүлэх.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС – ийн нэгдсэн номын сангаас гадна ОУХНУС өөрийн оюутанд үйлчлэх номын сан, уншлагын танхимтай.
- Суралцагчдаас шаардлагатай ном, сурах бичгийн хүсэлтийг авч, номын баяжуулалтыг хийдэг.
- Сургуулийн аль ч орчинд интернетэд холбогдох боломжтой бөгөөд JSTOR болон бусад нээлттэй судалгааны сангаас мэдээлэл авах боломж бүрдсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цахим болон хэвлэмэл ном, сурах бичгийн хүртээмж сайн.
- Төв номын сангийн орчин сайн, тав тухтай.

Зөвлөмж:

- Номын сангийн агуулах өрөөг агааржуулах, стандартын шаардлагад нийцүүлэх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- 2014 онд бүтцийн өөрчлөлт орж, бүрэлдэхүүн сургууль, тэнхим үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн.
- МУИС – ийн 2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөний хүрээнд бүх нэгжүүд ажиллаж байна.
- Тэнхим 2 долоо хоног тутам тэнхимийн хурлыг зохион байгуулах замаар асуудлаа хэлэлцэн, шийдвэрлэж байна.
- Удирдлагын мэдээллийн систем, Сиси системээр дамжуулан оюутны өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч, шийдвэрлэж байна.
- Бүрэлдэхүүн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгчид жил бүр МУИС-ийн удирдлагад тайлангаа танилцуулах замаар босоо түвшинд удирдлагын гүйцэтгэл үнэлэгдэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн стратеги, төлөвлөгөөтэй уялдаатай зорилго, зорилтууд тодорхойлогдсон.
- Хөтөлбөрийг сайжруулах, сургалтын чанарыг дээшлүүлэхэд оролцогч талуудын оролцоог ханган ажиллаж байна.
- Тэнхим аливаа асуудлыг багш нарын оролцоотойгоор шийдвэрлэх, тэнхимийн хурлыг тодорхой давтамжтайгаар хийж хэвшсэн байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын цахим хичээлийн бүрдэл, оюутанд үзүүлж буй үйлчилгээ харилцан адилгүй байна.

Зөвлөмж:

- Суралцагчаас ирж буй өргөдөл, гомдлыг бүртгэлжүүлэх, түүнд дүн шинжилгээ хийж, хариу үйлдлийн талаар жагсаалтаа хөтлөх.
- Нэгдсэн чанарын баталгаажуулалтын алба, тэнхимийн үйл ажиллагааны зааг ялгааг тодорхойлж, тэнхим өөрийн сургалтын чанарыг баталгаажуулах боломжит арга хэмжээг дотооддоо зохион байгуулах.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС – ийн Эрдэнэт сургуультай 2+2 хөтөлбөрийг эхлүүлсэн.
- ОХУ-ын МГИМО, БНСУ-ын Инха их сургууль, БНХАУ-ын ӨМИС, Тайванийн Үндэсний Чин Аний их сургуультай оюутан солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Суралцагчдын мэргэжлийн чадварыг дээшлүүлэх, харилцан бие биеэсээ мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор ГХЯ – тай хамтран загвар НҮБ хуралдааныг улсын хэмжээнд 5 дахь жилдээ зохион байгуулж байна.
- Үндэсний тагнуулын академи, Стратегийн судалгааны хүрээлэн, Дипломатын академи, ШУА – ийн Олон улс судлалын хүрээлэн, Далайд гарцгүй орнуудын олон улсын судалгааны төв зэрэг байгууллагуудтай суралцагч дадлага хийлгэх, зочин багш урьж лекц уншуулах замаар хамтарч ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн жилүүдэд багш солилцооны хөтөлбөрт 10 орчим багш хамрагдсан.
- Оюутан солилцооны хөтөлбөрт жил бүр 3 – 12 оюутан хамрагдаж байна. Сүүлийн 2 жилд Ковидын нөхцөл байдлын улмаас оюутны тоо буурсан.
- Төгсөгчийн холбооны үйл ажиллагаа тогтмолжсон.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах асуудлыг төгсөгчдөөс авч буй судалгааны үр дүнтэй уялдуулан тодорхойлох.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ сүүлийн жилд өссөн дүнтэй байна.

- Төсвийн гүйцэтгэлээс харахад, сүүлийн жилд судалгаа, эрдэм шинжилгээний зардал 70 хувиар нэмэгдсэн байна.
- Нэг суралцагчид ноогдох зардлын дүн сүүлийн жилд өссөн үзүүлэлттэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Судалгаа, эрдэм шинжилгээнд зарцуулах хувь хэмжээ, 1 суралцагчид ноогдох зардлын дүн өссөн нь эерэг үзүүлэлттэй байна.

Анхаарах асуудал:

- Санхүүжилтийн эх үүсвэрийн дийлэнх хувийг уламжлалт сургалтын төлбөрийн орлого эзэлж байна.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Маркетингийн идэвхжүүлэлтийг оюутан төгсөгчийн хэлтэс, элсэлт бүртгэлийн хэлтэс, хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэстэй хамтран хэрэгжүүлдэг.
- 2019 онд ажил олгогч, төгсөгч, оюутан, багш гэсэн 4 талт уулзалтыг зохион байгуулсан.
- МУИС – ийн сургалтын хуанли, календарь төлөвлөгөөнд тусгасаны дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулдаг.
- www.hutulbur.num.edu.mn цахим хуудсаар хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг түгээдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр сурталчлах арга хэмжээ, оролцогч талуудын уулзалтуудыг тогтмолжуулсан.
- Хөтөлбөрөөр суралцагчдын дийлэнх хувь нь буюу 75% нь өөрийн сонирхлоор орж ирсэн.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангахад удирдлагын мэдээллийн Сисис систем ашиглагддаг.
- МУИС, ОУХНУС-ийн веб хуудсаар дамжуулан мэдээллийг түгээхээс гадна Facebook page-ээр дамжуулан мэдээллийг хүргэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сошиал хуудсаар дамжуулан багш, оюутнууд хурдан шуурхай мэдээлэл солилцож, хэвшсэн байна.
- Онцлог үйл явдал, арга хэмжээнүүдийн талаар хэвлэмэл мэдээллийн хуудас, брошуруудыг давхар тарааж, мэдээллийг түгээж байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журмыг батлан, журмын дагуу элсэлтийг зохион байгуулж байна.
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа зохистой байна.
- Шинэ суралцагчдад зориулсан чиглүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулж, хөтөлбөр сурталчлах үйл ажиллганы төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Шинэ суралцагчдад зориулсан гарын авлагыг хэвлүүлэн өгдөг нь суралцагчдад дэмжлэг болдог.
- Гадаад оюутан олонтой бөгөөд, тэдний бүртгэлийн хавтсыг хөтөлдөг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчдийн дундаж оноо сүүлийн жилүүдэд өссөн үзүүлэлттэй, дундаж оноо 700 – аас дээш.
- Чиглүүлэх сургалтыг зохион байгуулдаг.
- “Суралцагчийн гарын авлага”-ыг жил бүр шинэчлэн хэвлэж, тараах үйл ажиллагаа тогтмолжсон.
- МУИС вэбсайт, Сиси программ хэрэглээнд бүрэн нэвтэрсэн.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сэтгэл ханамжийн судалгааг улирал тутам авч, үр дүнг үнэлдэг.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээг тогтмол гаргадаг.
- Зөвлөн чиглүүлэх үйлчилгээний төлөвлөгөө гарган ажиллаж, тайлагнадаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан, төгсөгчийн хэлтэс ажиллаж, зохих үйлчилгээг үзүүлдэг.
- Карьер хөгжлийн төв сургуулийн дэргэд ажилладаг.
- Хөтөлбөрийн зөвлөх багшийн томилгоо, оюутныг хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, үйл ажиллагаа тогтмолжсон.

Анхаарах асуудал:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны асуулгын дүн мэдээ, үр дүнд хийсэн дүгнэлт шинжилгээ, сайжруулах ажлын төлөвлөгөө тодорхойгүй, ахиц дэвшлийг тодорхой харуулах мэдээлэл хомс.

Зөвлөмж:

- Оюутны гомдол, санал, хүсэлт хүлээн авч шийдвэрлэх дүрэм журам гаргах. Хэдийгээр Сиси системээр дамжуулан дүнгийн гомдлыг хүлээн авч байгаа боловч, бусад төрлийн гомдол саналууд хаана бүртгэгдэж, хэнд очих нь тодорхой байвал, оюутны үйлчилгээ сайжирна гэж үзэж байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- 2015 оноос сургуулийн зүгээс оюутнуудын клубын үйл ажиллагаанд жил тутам санхүүжилт олгож хэвшсэн байна.
- Суралцагчдаас авсан судалгаанаас үзэхэд, тэдний мэргэжлийн хөгжилд клубын үйл ажиллагаа чухал нөлөөтэй гэж 42 хувь нь үзсэн бол, үйл ажиллагааг хангалттай сайн хэмээн 48 хувь нь үнэлсэн байна.
- Тус хөтөлбөрөөр суралцагчдын 38 хувь нь ямар нэгэн мэргэжлийн олимпиад, уралдаанд оролцсон туршлагатай байна.
- Тэнхимийн дэргэд Дипломат клуб, загвар НҮБ, ярианы клуб, оюутны дугуй ширээний уулзалтын клуб зэрэг 4 клуб идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутанд чиглэсэн олон төрлийн клуб, дугуйлантай, үйл ажиллагаа тогтмолжсон. Клуб дугуйлангийн үйл ажиллагаанд төгсөгч, ажил олгогч нарын оролцоог тогтмолжуулсан.
- Оюутны клубийн үйл ажиллагааг бодлогоор дэмждэг, сургалтын журамд зардал тусгагдсан.
- Оюутнууд улсын болон олон улсын олимпиадад оролцож ирсэн.

Анхаарах асуудал:

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээлэл тодорхой бус, цагийн ажилд зуучилсан оюутны тоон мэдээлэл, үнэлгээ тайлан хомс.
- Сургуулийн суралцах орчны тохижилттой холбоотойгоор оюутны оролцоог нэмэгдүүлэх, энэ чиглэлд оюутны холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэх.

Шаардлага:

- Сайн дурын ажлын цагийг хөтөлбөртөө тусгах, үнэлгээтэй болгох тал дээр бусад их, дээд сургуулиуд болон гадаадын их, дээд сургуулиудын туршлагыг судлах, боломжийг эрж хайх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчид шилжин суралцах боломжийг олгож, “МУИС – д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- Шилжилтийн бүртгэлийг хичээлийн жилд 2 удаа <http://burtgel.num.edu.mn> хаягаар хийдэг. Шалгалтын зохион байгуулалтыг элсэлтийн алба хариуцан ажилладаг.
- Шилжин ирэгсдийн квотыг МУИС-аас баталдаг. Энэхүү квотын хүрээнд суралцагчдыг элсүүлэн суралцуулж байна.
- Сүүлийн 3 жилийн дунджаар тус хөтөлбөрт шилжин суралцахыг хүссэн хүсэлт гаргагчдын тоо МУИС-ийн хэмжээнд хамгийн өндөр байна.
- Багц цагийг дүйцүүлэн тооцох асуудлыг “МУИС – д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-д тусгасан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаадын их дээд сургуулиас шилжин ирэгсдийн багц цаг дүйцүүлэх аргачлал нэвтрүүлсэн.
- Тус хөтөлбөрт шилжин ирэгсдийн тоо, бусад хөтөлбөрт шилжин суралцагчдын тооноос байнга өндөр хувьтай байдаг.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрөөр тогтвортой суралцагчдын хувийг жил бүр тооцоолон, дүн шинжилгээ хийх.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийг БШУЯ – наас баталсан бакалаврын зэргийн дипломын загварын дагуу хэвлэж, төгсөгчдөд олгодог.
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журам тодорхой, журмын дагуу үйл ажиллагаа зохион байгуулагддаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичиг нь холбогдох, батлагдсан дүрэм журмын дагуу олгогддог.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-д багш сонгон шалгаруулах, албан тушаалын зэрэглэл тогтоох хөдөлмөрийн дотоод журам, МУИС – д профессор багш ажиллуулах журмыг мөрдлөг болгодог.
- Багшийн судалгаа, эрдэм шинжилгээг дэмжих чиглэлээр судалгааны санхүүжилтийн журам, шагнал урамшууллын нийтлэг журам үйлчилдэг.
- МУИС-ийн 2016-2024 оны стратеги төлөвлөгөөнд “МУИС – ийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн хүний хөгжлийг хангах, багш ажилтны тасралтгүй хөгжих орчин бүрдүүлж, идэвх санаачлагатай ажиллах хөшүүрэг бий болгоно” хэмээн тусгасан.
- Шилдэг профессоруудыг ажиллуулах зорилгоор эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээрээ олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгдсэн эрдэмтдийг сонгон шалгаруулалтгүйгээр профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллуулахаар тусгасан.
- Нийт 15 багштай, түүнээс 9 багш нь буюу 60 хувь нь докторын зэрэгтэй байна.
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг сургуулиас дэмждэг, докторантурт суралцахад, сургалтын төлбөрийн дэмжлэг олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн 2016-2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөний зорилт 4-т МУИС-ийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн хүний хөгжлийг хангах, багш, ажилтны тасралтгүй хөгжих орчин бүрдүүлж, идэвх санаачилгатай ажиллах хөшүүрэг бий болгоно гэж тодорхойлсон. Энэ дагуу “шилдэг багшлах бүрэлдэхүүнийг бүрдүүлэх” бодлогыг баримталж байна.

- Багш нарын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор бие даасан судалгааны санхүүжилтийн журмыг батлан, мөрдөж байна.
- Доктор багшийн эзлэх хувь өндөр бөгөөд, цаашид 70 хувь хүргэх зорилт тавин ажиллаж байна.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- 2016 онд Багшийн хөгжлийн төвийг байгуулан, үйл ажиллагааг эхлүүлсэн. Багшийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулан, хөгжлийн хөтөлбөрийг тодорхойлсон.
- Багшийн хөгжлийн төв үйл ажиллагаагаа эхлүүлснээр багшийн заах арга зүйн үнэлгээ сүүлийн жилүүдэд өссөн.
- Багшийг хөгжүүлэх хөтөлбөрт туссан үйл ажиллагааг хэрэгжүүлж, багш нар дотоодод төдийгүй гадаадад мэргэжил дээшлүүлэх боломж нэмэгдсэн.
- Сүүлийн 3 жилд нийт давхардсан тоогоор 17 багш гадаад, дотоодын 20 гаруй төрлийн сургалтад хамрагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн www.research.num.edu.mn сайт үүсгэн багш нарын эрдэм шинжилгээ, нийгмийн үйлчилгээний ажлыг бүртгэх, гүйцэтгэлийг хянах, эрдэм шинжилгээний ажлын сан үүсгэн, гүйцэтгэлийн чанар болон ахиц дэвшилд судалгаа хийх, судалгааны түвшнийг тодорхойлох боломжтой болсон.
- Багш нар гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад тогтмол хамрагддаг.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, үр дүнд анхаарч ажиллах

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС дотооддоо судалгааны төслийн нээлттэй сонгон шалгаруулалт хийдэг болсон.
- Багш, суралцагчдын хамтын судалгааг дэмжих зорилгоор “Багш оюутны гарааны бизнес” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
- МУИС – ийн сургалтын нэгдсэн албатай хамтран бакалаврын хөтөлбөрүүдийг мэргэжлийн сурах бичгээр хангах захиалгат төслийг хэрэгжүүлж, Олон улсын харилцааны мэргэжлийн цогц сурах бичигтэй болсон.

- 2016 онд Бодлогын судалгааны төвийг байгуулж, Засгийн газрын болон төрийн бусад байгууллагуудын стратегийг тодорхойлох захиалгат төслүүдийг гүйцэтгэх болсон.
- Сүүлийн 3 жилд жил бүр Web of science-д бүртгэлтэй сэтгүүлд 2-3 бүтээл хэвлүүлсэн байна.
- Нэг багшид ноогдох судалгааны өгүүллийн тоо МУИС-ийн хэмжээнд 2.75 байгаа бол, ОУХ-ны тэнхимийн хувьд 5.4 байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын судалгааны санд бүртгэлтэй сэтгүүлд бүтээлээ хэвлүүлсэн багш нар олон буюу МУИС-ийн хэмжээнд судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чансаагаараа дээгүүр байр эзэлж байна.
- Багш бүр судалгаа, эрдэм шинжилгээний ажлын хувийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Гадаадын их, дээд сургуулийн профессоруудтай хамтарсан судалгааг өргөжүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллаж байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн жилийн эхэнд багш бүр ажлаа төлөвлөн тэнхимийн хурлаар танилцуулж, хичээлийн жилийн эцэст тайлангаа тэнхимийн эрхлэгчид өгдөг.
- МУИС-ийн хэмжээнд “Багш нарын аттестатчилалын журам” – г мөрдөж ажилладаг.
- Багшийн ажлыг хөндлөнгөөс үнэлүүлэх зорилгоор суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч хэвшсэн.
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны дундаж үнэлгээ 2-оос дээш байгаа нь Олон улсын харилцааны тэнхимийн багш нарын заах арга зүй болон харилцаа, хандлага сайн байгааг илэрхийлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөндлөнгийн үнэлгээний үр дүнд гаргасан төлөвлөгөө, хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ тодорхойгүй

Шаардлага:

- Хөндлөнгийн үнэлгээнд дүгнэлт шинжилгээ хийж, цаашид сайжруулах ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний хэрэгжилтийн тайлан гаргаж хэвших

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- 2017 онд МУИС – ийн бүтцэд Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын албыг байгуулсан бол, 2018 онд өөрчлөлт оруулж, Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.
- Энэхүү хэлтэс нь хөтөлбөрийг нээх, батлуулах, хэрэгжүүлэх, өөрчлөхтэй холбоотой асуудлыг хариуцахаас гадна тэнхимүүдэд хөтөлбөртэй холбоотой тоо баримтыг гаргаж өгөх, мэдээллээр хангах, хөтөлбөрийн үйл ажиллагаанд байнгын хөндлөнгийн үнэлгээ хийх, заавар, чиглэл өгөх, магадлан итгэмжлэлийг удирдлагаар ханган ажиллах үүрэгтэй.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Чанарын баталгаажуулалт хариуцсан хэлтэс байгуулагдаж, эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн.
- Чанарын баталгаажуулалтын хэлтсээс хичээлийн давхардлын судалгаа, ерөнхий суурь хичээлийн сурах бичгийн хангамжийн судалгаа, бакалаврын хөтөлбөрийн хичээлүүдийн уялдаа холбооны судалгаа, хос болон хавсарга хөтөлбөрийн судалгаа гэх мэт олон төрлийн судалгааг хийжээ.

Анхаарах асуудал:

- Судалгааны үр дүнгүүд хэрхэн хэрэглээнд орсон, чанарын баталгаажуулалтын хэлтсээс тэнхимд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байдал дутмаг.
- Тэнхим оролцогч талуудын судалгааны үр дүнд тулгуурлан, дотооддоо хийх ажлын төлөвлөгөө, сайжруулалтын арга замыг тодорхойлсон байдал сул.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн динамик, түүнд хийсэн шинжилгээ, оролцогч талуудад эргэн мэдээлсэн эсэх нь тодорхойгүй байна.
- Тэнхим өөрөө чанарын дотоод баталгаажуулалтыг хэрхэн хангадаг талаар илүү тодруулах шаардлагатай.

Шаардлага:

- Тэнхим өөрөө чанарын баталгаажуулалт хийх шалгуур үзүүлэлтүүдээ тодорхойлж, чанарын баталгаажуулалтын нэгдсэн хэлтсийн бодлоготой уялдуулах.
- Чанарын баталгаажуулалтын хэлтсээс өгч буй мэдээлэлд дүн шинжилгээ хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллах.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчийн ажил эрхлэлтийн дундаж 73%, үүнээс мэргэжлээрээ ажиллаж буй хувь 60 орчим хувьтай байна. МУИС-ийн хэмжээнд ажил эрхлэлт, мэргэжлээрээ ажиллаж буй хувь хамгийн өндөртэй хөтөлбөр байна.
- Төгсөгчдийн 50-иас илүү хувь нь 3 сарын дотор ажлын байртай болсон байна.
- Төгсөгчдийн дундаж орлого 1.9 сая төгрөг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллаж буй хувь өндөр.
- Олон улсын харилцаа, бодлого судлалын чиглэлээр үндэсний томоохонд тооцогдох судалгааны байгууллагуудын дийлэнх хүний нөөцийг энэ сургуулийн төгсөгчид бүрдүүлж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн мөшгөх судалгааг хийж хэвших.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн судалгааны үр дүнг хөтөлбөрт оруулсан өөрчлөлттэй уялдуулан харьцуулалт хийж үзэх.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөр нь 2013 онд 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.
- Шинжээчдийн багаас тухайн үед өгч байсан зөвлөмжүүдийн дагуу гадаад харилцаагаа сайжруулахад анхаарч, оюутан солилцооны болон багш солилцооны хөтөлбөрүүдийг эрчимжүүлсэн.
- Онлайн сургалт явуулах орчинг бүрдүүлэх, ном сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр цахим сургалтын журмыг боловсруулан, Microsoft Teams программыг ашиглан холимог сургалтыг зохион байгуулж байна.
- Олон улсын магадлан итгэмжлэлд орох зорилгыг хөтөлбөрийн баг тодорхойлсон байгаа тул, эхлэл тавигдсан гэж үзэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэх үйл ажиллагаа явагдаж байна

- Өмнөх шинжээчдийн өгсөн зөвлөмжийн дагуу гол гол ажлууд хийгдсэн.

Зөвлөмж:

- Мэргэжлийн онцлог, төгсөгчдийн олон улсын хөдөлмөрийн зах зээлд гарах боломж зэргийг харгалзан, олон улсад магадлан итгэмжлүүлэх ажлаа эрчимжүүлэх.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шинжээчийн баг МУИС-ийн ОУХНУС-ийн “Олон улсын харилцаа” бакалаврын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримтуудтай танилцаж, оролцогч талууд болох ажил олгогч, төгсөгч, суралцагч, багш нарын төлөөлөлтэй уулзаж, ярилцан 2 өдрийн турш сургууль дээр ажиллалаа. Энэхүү хөтөлбөр нь 2 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэхээр шинжээч ажиллуулсан бөгөөд хөтөлбөрийг 2014 онд шинэчлэн, үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалын дагуу төгсөгчийн загварыг мэдлэг, мэргэжлийн чадвар, хөрвөх чадвар, хандлага гэсэн 4 бүлгийн дагуу тодорхойлж батлуулсан байна. 2018 онд хөтөлбөрт агуулгын шинэчлэл хийн, сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан бөгөөд хөтөлбөрийг сайжруулах оролдлогыг тасралтгүй хийж байгаа нь харагдсан. “Олон улсын харилцаа” хөтөлбөрийн онцлог нь олон улсын харилцаа, дипломат харилцааны мэргэжлийн ур чадвар сайтай, гадаад хэлний өндөр чадвартай мэргэжилтэн бэлтгэдэгт оршино. 2018 онд оруулсан өөрчлөлтөөр МУИС-ийн хэмжээнд чөлөөт сонголтын хичээлийг нэмэгдүүлж, оюутанд ирээдүйн карьер төлөвлөлттэйгөө уялдуулан бусад салбарын хичээлүүдээс судлах боломжийг олгосон нь давуу талтай боловч, хоёр дахь гадаад хэлийг 3 улирал судлах болсоноор энэ хичээлээр олгогдох чадварт сөрөг нөлөө үзүүлсэн байж болзошгүй байна.

Тэнхимийн багш нарын талаас илүү хувь нь докторын зэрэгтэй, судалгаа шинжилгээ идэвхитэй хийдэг болох нь уулзалт болон нотлох баримтуудаас харагдлаа. Элсэгчдийн чансаа өндөр, тогтвортой суралцах хувь өндөр байгаа нь тус хөтөлбөрийн давуу тал болж байна. Суралцах орчны хувьд МУИС-ийн зүгээс бодлогоор шат дараалсан алхмуудыг хийсэн нь үр дүнгээ өгсөн байна хэмээн үзлээ.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангас	Хангаагүй	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2	1.3		Хөтөлбөрийн баримт бичиг үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан боловч, хичээлийн хөтөлбөрүүд шинэ загварын дагуу бүрэн баталгаажуаагүй, эмх цэгц муутай.
2	Сургалтын үйл ажиллагаа	2.2, 2.3	2.1		Хөтөлбөрийн агуулгын өөрчлөлтийн үр дүнг харах шинжилгээ хийгдээгүй, 2 дахь гадаад хэлний багц цагийг бууруулсан нь төгсөгчдийн болон ажил олгогчдын сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлж байна.
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.1 3.2 3.3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.1 4.2 4.3,4.4 4.5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5.1,5.2 5.4, 5.5	5.3		Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хийгдсэн ажлын тайлан тодорхой бус байна.
6	Багшийн үйл ажиллагаа	6.1, 6.2, 6.3,	6.4		Багшийн үнэлгээний үр дүнд хийх ажлын төлөвлөгөө, сайжруулалтын арга хэмжээг төлөвлөж хэвшээгүй.
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	7.2, 7.3	7.1		Оролцогч талуудаас судалгаа авах үйл явц тогтмолжсон боловч, түүний үр дүнг шинжилж, цаашдын төлөвлөгөөнд тусгах асуудал дутагдалтай байна.
	Бүгд	21	5		
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол улсын их сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн “Олон улсын харилцаа” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Нийгмийн ухааны чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэгС.Эрдэнэтуул

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Н.Хосбаяр

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....И.Энхболд

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Хичээлийн хөтөлбөрүүдийг суралцахуйн зорилтот үр дүн, түүнийг олгох сургалтын арга, үнэлгээний аргыг дэлгэрэнгүй тусгасан шинэ загварын дагуу боловсруулж, баталгаажуулан жигдлэх.
2. Цахим сургалтын болон суралцагч төвтэй сургалтын шинэ арга зүйн талаар багш нарт дэмжлэг үзүүлэх гарын авлага, удирдамжийг бэлтгэн, хэрэглээнд оруулах.
3. Суралцагчдад олгож буй гадаад хэлний ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр судалгаанд үндэслэн дахин сайжруулалт хийх.
4. Чанарын баталгаажуулалтыг хангах чиглэлээр хийж буй ажлуудаа цаашид тогтмолжуулан, үр дүнг хэрэглээнд оруулах, сайжруулалтын төлөвлөгөөнд тусгах тал дээр анхаарч ажиллах.
5. Олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагаагаа эрчимжүүлж, төгсөгчдийн олон улсын хөдөлмөрийн зах зээлд гарах боломжийг дээшлүүлэх.
6. Чанарын баталгаажуулалтын нэгдсэн албанаас авч буй судалгааны үр дүнг хөтөлбөр, тэнхим нэгжээр гарган, үр дүнг хэрэглээнд оруулах тал дээр илүү анхаарч ажиллах.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Заадаг хичээл
1	Ж.Баттогтох	Тэнхимийн эрхлэгч	доктор	Олон улсын эрх зүй
2	Г.Баасанхүү	Ахлах багш	Магистр	Олон улсын харилцааны түүх, Олон улсын харилцааны онол
3	С.Энхцэцэг	Дэд профессор	доктор	Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа, орон судлал
4	Б.Мөнх-Өлзий	Ахлах багш	доктор	Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, Судалгааны арга зүй
5	Б.Тэргэл	Ддлагажигч багш	Магистр	Олон улсын харилцааны үндэс ба даяаршил
6	С.Оюунсүрэн	Ахлах багш	доктор	Бүс нутаг судлал, Монголын дипломатын түүх
7	Ж.Баттөр	Дэд профессор	Доктор	Монгол ба хөрш орнуудын харилцаа, Монгол улсын гуравдагч хөршийн бодлого
8	С.Баясгалан	Дэд профессор	Доктор	Монгол улсын гадаад бодлого Олон улсын аюулгүй байдал

II. Оюутны нэрс

№	Оюутны овог нэр	Түвшин	Сонгосон байдал	Суралцагчийн голч дүн	Холбоо барих утас мэйл хаяг
1.	Г.Алтайхүү	IV	Сурлага	3.9	80261830 altaikhuugal@gmail.com
2.	Yun Ahyun	IV	Гадаад оюутан	3.7	86698291 jimsee0403@gmail.com
3.	Lee Yeon Ju	III	Гадаад оюутан	3.3	91144166 yeonju1999@gmail.com
4.	Б.Агиймаа	IV	Дипломат Клуб	3.6	95196268 a1g2i3i4m5a6a@gmail.com
5.	Баясгалан	IV	Судалгааны амжилт	3.9	94919139 bayasgalan.gankhуu77@gmail.com
6.	Д.Хатанзаяа	II	Клуб	3.7	dhatanзaya2545@gmail.com 95509888
7.	З.Дүүрэнжаргал	IV	Оюутны байр	3.6	88227184 z.duuree20@gmail.com

8.	Ч. Дариймаа	III	Орон нутаг	3.7	80191107 dariimach123@gmail.com
9.	Г. Номин-Эрдэнэ	IV	Орон нутаг	3.9	89555342 nominerdeny@gmail.com
10.	О.Дорж	IV	Оюутны зөвлөл	3.7	89215521 dorj89215521@gmail.com
11.	Т.Энхчимэг	III	Нийгмийн идэвх /Model UN гэх мэт/	3.7	91345577
12.	Халиунаа	IV	Сайн үйлс	3.9	88777709 tungaakhaliun@gmail.com
13.	Урангоо	IV	Интро клуб	3.6	99796122 urangookhongorzul28@gmail.com
14.	Гүнбилигт	IV	Мини Парламент	3.5	89657993 gunbiliqt12@gmail.com
15.	Пүрэвмаа	III	SRT	3.9	89769858 purevmaab4@gmail.com
16.	Удвал	III	Сайн үйлс	3.6	88710315 udkanakana@gmail.com
17.	Гүнчин-Иш	IV	Аюулгүй байдал, стратеги судлалын клуб	3.4	99608551 gunchinish.kh@gmail.com
18.	Хонгорзул	IV	Хөгжлийн бэрхшээлтэй/75%/, 2+2 хөтөлбөр	3.9	88566516 khongorzulpurev@gmail.com
19.	Халиун	IV	Урлаг	3.6	80884022 khaliunerka.2000@gmail.com
20.	Б.Сайхангомбо	IV	Спорт	3.2	88451021 gombo008@gmail.com
21.	Итгэл	IV	Тэтгэлгээр яваад ирсэн	3.7	90054664 itgelsport@gmail.com
22.	Н.Идэрбат	IV	Бусад тэтгэлэгт хамрагдсан	3.8	89921168 iderbatnyamdorj1168@gmail.com
23.	Л.Солонго	IV	Нийгмийн идэвх	3.7	95801098 solongolkhamkhuu@gmail.com

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Г.Амартүвшин	Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар	Бодлого хэрэгжилтийн газрын дарга
2	Г.Бямбасүрэн	ГХЯ	Бодлого, төлөвлөлтийн газрын дэд захирал
3	Д.Золбоо	ШУА – ийн ОУСХ	захирал
4	Д.Соёлмаа	НҮБ – ын суурин зохицуулагчийн газар	Суурин зохицуулагчийн газрын ХМХ хариуцсан ахах мэргэжилтэн
5	Б.Майцэцэг	ХИС	ОУХ- ны тэнхимийн эрхлэгч
6	Н.Батгэрэл	BDSec ХХК	Дэд захирал

7	Г.Чинзориг	Specialized Career Consulting LLC	Захирал
8	Б.Гэрэлмаа	СЭЭКЛ ХХК	Хүний нөөцийн албаны дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Б.Билгүүн	Гадаад харилцааны яам	Америк, Ойрхи, Дорнодын газрын ажилтан
2	Ж.Болор	БШУЯ	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн
3	С.Сутайбилгэ	Шүүхийн ерөнхий зөвлөл	Хоёр талт хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
4	Ж.Тэнгис	ҮБХИС	Багш
5	Г.Намуун	ЮНЕСКО	Монголын үндэсний комиссын мэргэжилтэн
6	Б.Бүжин	НҮБ	ХХАА – ын байгууллагын захиргааны ажилтан
7	М.Удвал	АНУ-ын ЭСЯ	Иргэн, цэргийн дэмжлэгийн бүлгийн соёлын зөвлөх
8	О.Мишээл	АНЭУ-ын ЭСЯ	Олон нийттэй харилцах мэргэжилтэн
9	Л.Оюу	Азийн сан	Төслийн ажилтан
10	Б.Уранцэрэн	Uni's English House	Багш
11	М.Зоригт	Оюу толгой ХХК	Төр олон нийттэй харилцах хэлтэст хэвлэл мэдээллийн хяналт хариуцсан ажилтан
12	Э.Мөнгөн шагай	“Говь” ХХК	Онлайн худалдааны газар менежер
13	Т.Мөнх-Эрдэнэ	Рио Тинто Монгол ХХК	Бизнесийн үйл ажиллагаа хариуцсан шинжээч
14	Э.Чинболд	Японы Нагоягийн ИС	магистрант
15	А.Хоролжав	Shanghai Jiao Tong university	магистрант

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА,
НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот-46/а ш/х-6, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 5, Утас/Факс: (976-11) 35-46-10,
E-mail: sirpa@num.edu.mn, http://sirpa.num.edu.mn

2021. 11. 18 № 09/111

танай _____-ны № _____-т



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

2021 оны 11 дүгээр сарын 2-3-ний өдрүүдэд тус сургуулийн Олон улсын харилцааны хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн дүгнэлттэй танилцлаа. Дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ



С.БАТТУЛГА